



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/07

Өмнөдэлгэр сум

**Нягтлан бодох бүртгэлийн
бодлогын баримт бичиг батлах тухай**

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, 17 дугаар зүйлийн 17.1.3, 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Сангийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2023 оны А/229 дүгээр тушаалыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг хавсралтаар баталж, 2025 оны 01 дүгээр дугаар сарын 02-ны өдрөөр тооцон санхүүгийн үйл ажиллагаанд дагаж мөрдсүгэй.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, байгууллагын санхүүгийн тайланг заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягыг баримтлан гаргах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавьж ажиллахыг нягтлан бодогч (М.Алтантуяа), нярав (Д.Даваасүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дотоод хяналт шалгалтын багийн ахлагч (Э.Хэрлэн)-д даалгасугай.

**ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ** **Ж.СУГАРРАГЧАА**

